

Христофор Колумб Америкийг нээсний
500 жилийн ойд зориулав.

АМЕРИКИЙН ТҮҮХ, ӨНӨӨГИЙН БАЙДЛААС ӨГҮҮЛЭХ НЬ

М.Хурметхан (дэд эрдэмтэн)

Умард Америкт индианчууд олон мянган жилийн өмнөөс нутаглаж байсан бөгөөд тэд Бөрингийн хоолойгоор дамжин Америкт ирсэн байжээ.

1492 онд Италийн далайчин Христофор Колумб "Санта Мариа" хэлгээрээ их далайг гатлан "Шинэ ертөнц"-ийг санамсаргүй нээснээс хойш 500 жил улиран өнгөрчээ. Түүнээс хойшхи 100-аад жилд Англи, Испани, Португали, Герман, Францын шинжээчид шинэ ертөнцийг үзэхээр далайгаар аялан алдар хүндээ дуурсах, алт, баялаг эрж очих нь элбэг болжээ.

Шинэ ертөнцөд ирж суурьшигчид нь янз бүрийн зорилгоор тухайлбал, эдийн засгийн таатай нөхцөл, шашны болон улс төрийн эрх чөлөө хүсэн ирдэг байжээ. 1607 онд Английн оршин суугчдын хэсэг нь анхны байнгын суурин газарбайгуулснаа Английн хаан Жеймсийн нэрээр Жеймстон хэмээн нэрлэсэн тэр үеэс Америкийн түүх эхэлсэн гэлцдэг ажээ.

Умард Америкийг ХҮ1-ХҮП зуунд европынхон колоничлож эхэлжээ. Үүнд: Англи, Испани, Франц, Нидерланд, Швец зэрэг орнууд юм. Англи колоничлолоо хурдавчилсан байна. ХҮШ зууны 60-аад онд Англи улс Умард Америкийн ихээхэн нутгийг эрхшээлдээ оруулж авсан байв. Колоничлогчид Индианы уугуул аймгуудыг үржил шимтэй газраас зайлуулсан юм. Энэ үеэс тус оронд капиталист нийгмийн харилцаа хөгжиж эхэлсэн байна. Энд голдуу Англи, Нидерландаас ирэгдэж ирж суурьшиж эхэлсэн юм. Шинэ Англид (одоогийн АНУ-ын зүүн хойд хэсэгт) ХҮП зууны хоёрдугаар хагаст гар үйлдвэрлэл хөгжиж эхэлсэн боловч Английн колоничлогчид эдийн засгийн хөгжлийн хурдцыг хангаж чадахгүй байв. ХҮШ зууны 60-аад онд фермерүүдийн хөдөлгөөн нэлээд өргөжсөн байна. 1775-83 онд Умард Америкт тусгаар тогтнолын төлөө байлдааны ажиллагаа явагджээ. Энэ бол Английн колоничлогчдын эсрэг америкийн ард түмний тусгаар тогтнол, эрх чөлөөний төлөө тэмцэл байлаа. Тусгаар тогтнолын төлөө явуулсан байлдаан нь хувьсгалын шинжтэй болов.

1776 оны 7-р сарын 4-нд Умард Америк дахь английн колониудын оршин суугчдын төлөөлөгчдийн 2-р их хурал "Тусгаар тогтнолын Тунхаглал" гарган Америкийн Нэгдсэн Улс байгуулагдсаныг зарласан байна.

Английн эсрэг дайнд Америкчууд ялав. 1783 онд Версальд гарын үсэг зурсан хэлэлцээрийн болзлын дагуу Америкийн тусгаар тогтнолыг Англи улс хүлээн зөвшөөрчээ. 1787 онд АНУ-ын Үндсэн хуулийг батлав. Ж.Вашигтон АНУ-ын анхны ерөнхийлөгчөөр (1789-97) сонгогдов. 1791 онд Үндсэн хуульдаа нэмэлт оруулан, эрхийн тухай Билль (хууль) батлан, түүндээ ардчилсан эрхийн анхны 10 нэмэлтийг оруулсан юм.

XIX зууны эхэнд АНУ-ын нутаг дэвсгэр өргөжиж, 1803 онд Джефферсоны Засгийн назар Францаас Луизианыг худалдан авав. 1819 онд Испаниас Флоридыг бас худалдан авав. 1823 онд Монро-гийн номлолыг зарласан байна. 1846-48 оны хооронд Америк-Мексикийн дайн болж, түүний үр дүнд Мексикийн нутгийн хэсэг Америкт шилжсэн байна. 1867 онд АНУ Оросоос Аляскыг худалдаж (7,2 сая доллар) авлаа.

XIX зууны нэгдүгээр хагаст АНУ-д хар арьстан нарыг чөлөөлөх тэмцэл өрнөв. Боолчлолыг устгахын төлөө тэмцэл бол 1859 оны бослогоос хойш онцгой хүчтэй болов. Боол эзэмшигч өмнөд хэсэг, боолчлолыг устгасан хойд хэсгийн хооронд зөрчил хурцдан иргэний дайн гарахад хүргэв. Боол эзэмших нь АНУ-д капитализм хөгжихөд саад болж байлаа. Энэ үед Бүгд Найрамдах Намын (1854) нөлөө хүчтэй болжээ. 1860 онд БН-аас нэр дэвшсэн А.Линкольн ерөнхийлөгчөөр сонгогдов. Тэрээр боол эзэмшигч штатууд Холбооноос гарахад нөлөөлсөн байна. Боолчуудад эрх чөлөө олгох тухай хууль 1862 оны 5-р сарын 20-нд батлагдсан нь чухал ач холбогдолтой үйл явдал болжээ. 1863-65 онд Иргэний дайныг шинэ аргаар явуулах болсноор хойд талын муж улсууд хүчээ авч удалгүй Конфедерацийн нийслэл байсан Ричмондыг холбооны цэргүүд 1865 оны 4-р сард эзлэн авч, Р.Ли нарын босогчдыг дарснаар иргэний дайн дуусав. Үүнээс хойш өмнөд хэсэгтээ хар, цагаан арьстны эрх тэгш эрх эдлэх талаарх хөдөлгөөн өрнөв. Энэ нь өмнөд хэсгийг өөрчлөн байгуулахын эхлэл болжээ. Хойд хэсгийн ялалтын үндсэн дээр Америкт капитализм хөгжих зам нээгдэв.

XIX зууны эцэст америкийн капитализм хөгжлийнхээ дээд шатанд шилжин оров. Испани-Америкийн дайн болов. 1899 онд АНУ Хятадад "Нээлттэй хаалгын" номлолыг зарлажээ. 1917 оны 4-р сарын 17-нд АНУ нь 1914-18 оны дэлхийн 1-р дайнд оролцон, Антантын талд байжээ. 1929-33 онд болсон эдийн засгийн хямралд АНУ нэгэн адил өртжээ. Эдийн засгийн хямралыг даван туулахын тулд эдийн засгийн салбарт ерөнхийлөгч Франклин Рузвельт хэд хэдэн арга хэмжээ авч явуулсан байна. Дэлхийн хоёрдугаар дайны явцад фашист Германы эсрэг нэг эвсэлд АНУ, Англи, ЗХУ нэгдэн оржээ. Дэлхийн II дайны төгсгөлд АНУ нь эдийн засгийн хувьд хүчирхэг гүрэн болсон байлаа.

Дэлхийн II дайн дууссаны дараах хэдэн арван жилд АНУ нь дэлхийн хүчирхэг гүрэн болж хөгжиж дэлхийн улс төр, эдийн засаг, цэргийн амьдралд ихээхэн нөлөөтэй болсон юм.

Христофор Колумб тус тивийг нээсэн тэр цагаас АНУ-ын түүх эх авч, өнөөгийн өндөрлөгт хүрсэн юм. Христофор Колумб шинэ ертөнцийг нээснээр хүн төрөлхтөний түүхэнд соёл иргэншлийн хэсгүй нэгэн одыг бий болгов. Шинэ ертөнц-шинэ ард түмэн, шинэ дэг журам, хүсэл мөрөөдөл бүрдэн цогцолж, хүний эрх, ардчилалыг дээдлэн, түүгээрээ манай гаригийн хүн ардад тодрон харагдаж байна.

Эдийн засаг

АНУ бол эдийн засгийн талаар дэлхийн хамгийн их хөгжсөн орны нэг юм. Хуучин "капиталист" хэмээн нэрлэгдэж байсан орнуудын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 45 хувийг ганцаараа үйлдвэрлэж байв. АНУ-ын эдийн засаг үсрэнгүй мөчлөгийн замаар хөгжиж байна. АНУ-д эдийн засаг нь хойд, өмнөд, баруун гэсэн гурван гол мужид хуваагдана. Эдгээр нь өөр хоорондоо өвөрмөц байх бөгөөд хойд муж илүү өндөр хөгжсөн байна. Энд боловсруулах болон хөдөө аж ахуйн таваарлаг салбар, цахилгаан, автомашины үйлдвэрлэл, хүнд аж үйлдвэр хөгжсөн байх жишээтэй.

Аж үйлдвэр бол АНУ-ын аж ахуйн голлох салбар юм. АНУ-д төмөр, болд, машины үйлдвэрлэл, электроник, радиотехник, сансар судлал, хими, барилгын үйлдвэр, сүлжмэл, оёдол, цаас, хоол хүнс, газ, цахилгаан үйлдвэрлэл өндөр хөгжсөн байна. АНУ-д хөнгөн, хүнд аж үйлдвэр зэрэг хөгжсөн боловч хүнд үйлдвэрийн салбар голлох юм. АНУ-д хөдөө аж ахуй, мөн өндөр хөгжилд хүрсэн байна. Тус оронд эдийн засгийн салбарыг хөгжүүлэхэд шинжлэх ухааны эрчимтэй хөгжил нь шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж ирсэн бөгөөд гүйцэтгэж байна. АНУ-ын эдийн засгийн хөгжлийн гол үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэнд үзүүлье.

АНУ-ын эдийн засгийн гол үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хэжих нэгж	1960	1963	1967
1. Нийт хүн өм	сая хүн	227,8	234,8	243,8
2. Үүнээс 0-14 насны	хувь	22,5	21,5	21,5
3. 60-аас дээш	(эр эм) хувь	13,6 17,8	14,3 18,7	14,5 19,1
4. Хотын хүн өм	хувь	73,7	73,9	74,0
5. Хүн өмийн жилийн өсөлт	хувь	1,1	1,0	0,8

6. Үндэсний нийт бүтээгдэхүүн	сая ам. дол.	2688470.0	3355470.0	4472910.0
7. ҮНБ-ний доторх өөрчлөлтийг удаан хугацааны байдлаар үзэх	хувь	3.4		3.2
8. Нэг хүнд ноогдох нийт бүтээгдэхүүний хэмжээ	ам. дол.	11804.0	14281.0	18364.0
9. Ажил эрхлэх чадвартай хүн ам	хувь (эр эм)		57140	57143
10. Ноогдох хөнгө оруулалтын асдат	нб-д харьцуу. хувь	19.0	17.0	17.0
11. Хав-н нийт бүтээгдэхүүн	нб-д харь	3.0	2.0	2.0
12. ХАА дахь ажиллах хүч	нийт ажиллах хүчинд харь хувь	3.0	2.0	2.0
13. ХАА-н бүтээгдэхүүний үнэ	1979-1981=100	93.0	88.0	98.0
14. Нэг хүнд ноогдох ХАА-н бүтээг үнэ	1879-1981=100	96.0	87.0	93.0
15. АҮ-ийн нийт үйлд. хэмжээ	нб-д харь хувь	28.0	27.0	
16. АҮ дахь ажиллах хүчин	нийт ажиллах хүчинд харь хувь	23.0	22.2	20.3
17. Бүтээгдэхүүн	НБ-д харь хувь	22.0	21.0	19.0
18. Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн үнэ	1981=100	102.0	101.0	119.0
19. Худалдах өөр зориулан үйлд. цахилгаан	эрчим хүч	1000мт	141462.0	1328467.0
20. Экспортын бараа	сая ам. дол.	225722.0	205639.0	254122.0
21. Импортын бараа	сая ам. дол.	256984.0	259878.0	42442.0
22. Саллцооны тогтоосон үнэ	сая ам. дол. ноогдох хувь	1.0	1.0	1.0
23. Хэрэглээний бараа	ны үнэ	1980=100	110.0	121.0
24. Бөөний барааны үнэ	1980=100	109.0	113.0	114.0
25. Ирсэн жуулчид	мян. хүн	22500.0	20441.0	28787.0
26. Хэрэгцээнд байгаа тээврийн хэрэгсэл (машин г.т)	1000 хүн амд ноогдох	666.8	697.2	701.5

6. Үндэсний нийт бүтээгдэхүүн	сая ам. долл	2688470,0	3355470,0	4472910,0
7. ҮНБ-ний доторх өөрчлөлтийг удаан хугацааны байдлаар үзэх	хувь	3,4		3,2
8. Нэг хүнд ноогдох нийт бүтээгдэхүүний хэмжээ	ам. долл	11804,0	14281,0	18364,0
9. Ажил эрхлэх чадвэртэй хүн ам	хувь (эр эм)		57,40	57,43
10. Ноогдох хөрөнгө оруулалтын асалт	нб-д харьцуу. хувь	19,0	17,0	17,0
11. ХАА-н нийт бүтээгдэхүүн	нб-д харь	3,0	2,0	2,0
12. ХАА дахь ажиллах хүч	нийт ажиллах хүчинд харь хувь	3,0	2,0	2,0
13. ХАА-н бүтээгдэхүүний үнэ	1979-1981=100	93,0	88,0	98,0
14. Нэг хүнд ноогдох ХАА-н бүтээг. үнэ	1879-1981=100	96,0	87,0	93,0
15. АҮ-ийн нийт үйлд хэмжээ	нб-д харь хувь	28,0	27,0	
16. АҮ дахь ажиллах хүчин	нийт ажиллах хүчинд харь хувь	23,0	22,2	20,3
17. Бүтээгдэхүүн	нб-д харь хувь	22,0	21,0	19,0
18. Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн үнэ	1981=100	102,0	101,0	119,0
19. Худалдахаар зориулан үйлд цахилгаан эрчим хүч	1000мт	141462,0	1328487,0	144499,0
20. Экспортын бараа	сая ам долл.	225722,0	205639,0	254122,0
21. Импортын бараа	сая ам. долл	256984,0	269878,0	42442,0
22. Соллидооны тогтоосон үнэ	сая ам долл ноогдох хувь	1,0	1,0	1,0
23. Хэрэглээний барааны үнэ	1980=100	110,0	121,0	138,0
24. Бөөний барааны үнэ	1980=100	109,0	113,0	114,0
25. Ирсэн жуулчид	мян. хүн	22500,0	20441,0	28787,0
26. Хэрэгцээнд байгаа тээврийн хэрэгсэл (машин г.т)	1000 хүн амд ноогдох	866,8	697,2	701,5

27. Хэрэгцээнд байгаа				
төл. Цэг	1000 хүн амд ног.	768.0	760.0	
28. Төлөвизор		684.0	790.0	913.0
29. 15 ба түүнээс дээш насны бичиг үсэг үл мэдэгч	хувь (эр эм)			
30. 1,2 шатны сургуульд элсэгчид		95 96	100 99	102 101
31. Улсаас боловсролын салбарт зориулах зардал	нб-д харьц. хувь			
32. Төрөлтөд зориулах зардал	жилээр (эр эм)	69 77	71 78	72 79
33. Нялхсын үхлийн хэсгээ	1000 төрөлтөд ногдох	14.0	11.0	10.0
34. Эрүүлийг хамгаалах салбарт ажиллагсад	1000 хүн тутамд		174.2	
35. Нэг хүний хоногийн дундаж хоол хүнсний хэмжээ	ккал	3529.11		3642.0

Шинжлэх ухаан, технологи

АНУ нь дэлхийн шинжлэх ухаан технологийн хөгжилд олон арван жилийн туршид алдар хүндээ хадгалан байна. XIX зууны сүүлчээр АНУ-д өндөр хөгжсөн аж үйлдвэр бий болсон нь шинжлэх ухааны хөгжлийг хурдасгаж өгчээ. Үүнд электротехник, машины үйлдвэр, нисэх онгоц үйлдвэрлэх явдал хөгжив. XX зууны эхэнд математикчид Б.Прис, Г.Биркгоф, Ж. Нейман, О Ве блен, физикчид Р.Опэнгеймер гэх мэт хүмүүсийн бүтээл нийтийн хүртээл болжээ. Атомын бүтцийн тухай орчин үеийн ойлголтыг хөгжүүлэхэд И.Ленгмер, Г.Льюисийн судалгаа чухал болов. АНУ-ын эрдэмтдийн электроник, радио

техник, нийлэг эдлэл хийх технологийн салбар дахь нээлт нь техникийн бусад салбарыг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй байжээ. XX зууны 30-аад онд АНУ-д шинжлэх ухааныг хөгжүүлэхэд Европоос очсон А.Эйнштейн, Г.Бете, Э.Ферми нар Америкийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэжээ. 50-аад онд Нобелийн шагналт -физикчид Л. Полдинг, У. Лэмбан, П.Куш, У. Шоклид, У.Братск, Ж.Бардин, Ли Чжендао, Ян Чжэньпин, Э.Сегрин, О.Чемберлен, биологичид С.Очаон, А.Копиберг гэх мэт бүтээлүүд дэлхийн олон нийтэд танил болжээ

Дэлхийн II дайнаас хойшхи 40 илүү жилд суурь болон хавсарга шинжлэх ухааныг талаар ихээхэн анхаарч төрөөс ихээхэн хэмжээний зардал гаргаж ирснээр тус орон одоо шинжлэх ухаан хөгжсөн тэргүүний орнуудын нэг болов. АНУ-д шинжлэх ухаан, технологийг үргэлжлүүлэн хөгжүүлэхэд холбооны төсөв, их сургуулиуд, хувийн үйлдвэр, хувийн фондуудаас жил бүр 67,930 сая ам. долларын хөрөнгө оруулан, 743000 эрдэм шинжилгээний ажилтан, ш.женерүүд ажилладаг байна. АНУ-ын эрдэмтэд дэлхийн шинжлэх ухааны өнөөгийн түвшинд тулгамдаж байгаа бүхий асуудлаар судалгаа явуулдаг. Үүнд эрчим хүчний шинэ эх булгийг нээх, нар газар дэлхийн судлал, анагаах ухааны гол салбарууд, сансар судлал гэх мэт юм. Энд АНУ-ын сансар судлалын ололын талаар тэсвч дурдъя. АНУ-д тийрэлтэт хөдөлгүүр, пуужин, дэлхийн хиймэл дагуул хийх, цөмийн хөдөлгүүр бүхий шумбагч онгоц хийх талаар асар их ажил хийжээ. 1958 онд анхны хиймэл дагуул хөөргөсөн тэр цагаас хойш Наса нь хүнтэй, хүнгүй хэдэн зуун сансрын хөлөг илгээжээ. "Аполлон-2" сансрын хөлөгийн нисэгчид саранд бууж, буцаж ирээ. Бусад гариг руу хиймэл дагуул явуулаад байна. "Колумбия", "Челленжер", "Дисковери", "Атлантис" зэрэг олон дахин ашиглах сансрын хөлгийг байнга ашиглаж байгаа юм. Кибернетик, тооцоолон бодох машин хийх, өнгөт төлөвд үйлдвэрлэх салбарт ихээхэн амжилтанд хүрчээ. Анагаах ухаан, биологи, биотехник гэх мэт шинжлэх ухааны салбар хурдацтай хөгжиж байгаа билээ.

Сүүлийн жилүүдэд Америк, Монголын шинжлэх ухааны салбарт хамтын ажиллагаа өргөжиж байгаа тус орны шинжлэх ухаан, технологийн өмнө тулгамдсан зорилтыг шийдвэрдэхэд ихээхэн сөйхөн боломж бий болгож байгаа юм. Түүнчлэн АНУ-ын шинжлэх ухаан, технологийн ололыг эзэмших, Монголын үндэсний боловсон хүчнийг бэлтгэхэд АНУ туслах ажил өргөжив. Энэхүү бололцоог бүрэн дүүрэн ашиглавал АНУ-ын шинжлэх ухаан, технологиос суралцан, ихээхэн зардал цаг хугацаа хэмнэн Монгол орно нөхцөлд тохируулан ашиглах болоцоо бидний өмнө нээлттэй байна.

Аливаа улс гүрэн харилцан бие биенээ судлан танин мэдэх нь хүн төрөлхтөний соёл иргэншлийн чухал нэгэн ололт байдаг билээ. Монгол, Америкийн ард түмэн газар нутгийн хувьд алслагдсан хэдий ч ойр дотно танилцан, харилцан ойлголцохыг чухалд үздэг юм. Сүүлийн жилүүдэд Монгол Америкийн харилцаа, улс төр, нийгэм, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, техникийн салбарт хөгжиж эхэлсэн нь үүний тод илрэл юм. Ялангуяа өөрчлөлт шинэчлэлтийн өнөө үед Америкт Монголын судлал, Монголд АНУ судлал хөгжиж байгаа нь чухал ач холбогдолтой юм.

1. АНУ-д Монголын судлаачыг эртнээс сонирхон хөгжүүлж ирсэн юм. Монголтой шинжлэх ухаан, соёлын хамтын ажиллагаа тогтоох, Монголын тухай үнэн бодит мэдээллийг АНУ-ын олон нийтэд өгөхөд америкийн монгол судлаач эрдэмтэд ихээхэн хувь нэмэр оруулсан юм. АНУ-д монгол судлаач

хөгжүүлэх болсны гол үндэс нь Монголын талаарх түүний олсон нийтийн болоод эрдэмтдийн эрдэм шинжилгээний сонирхол өссөн нэмэгдсэнээр тайлбарлаж болох юм. Монголын тухай Америкт 50-аад оноос нэн сонирхох болж, "Нью-Йорк таймс" сонин орлогч эрхлэгч Г.Сольсбери, сэтгүүлч А.Аксольбанк, нэрт монголч эрдэмтэн О.Латтмор, Азийн судлаач Р.Рупэн нарын монгол орны тухай бичсэн ном, өгүүлэл нь нийтийн анхаарал татаж, АНУ-д монгол судлалыг хөгжүүлэхэд түлхэц болжээ. АНУ-д сүүлийн 40-өөд жилд дорно дахины судлал, түүний дотор монголын судлалыг хөгжүүлэхэд тодорхой хэмжээгээр анхааран ирсэн түүхтэй юм. АНУ-д Вашингтон, Колумб, Гарвард, Индианы их сургуульд монгол судлалыг өрнүүлж ирсэн ажээ. Монголын судлалын ажлыг зохицуулах, программчилах, төвлөрүүлэх ажил энд бас хийгджээ. АНУ-д монголын судлалын номзүй, мэдээлэл олох систем бүрдэж, үндэсний мэргэжсэн монгол судлаачид, ялангуяа монгол хэл судлаачдыг бэлтгэх ажилд гол анхааран, суралцах оюутан, судлаачдын тоог нэмсэн юм. "Монголын нийгэмлэг" хэмээх ашиг хонжоо үл хайгч, улс төрийн бус хувийн шинжлэх ухааны холбоог 1961 онд АНУ-д байгуулжээ. Тус нийгэмлэгийн гол зорилго нь Монголын түүх, хэл, соёлыг судлан монголын судлалыг хөгжүүлэх явдал юм. Уг холбоо анх 60 хүнтэй байгуулагдсан бол 1968 он гэхэд 150 гаруй хүнтэй болжээ. "Монголын нийгэмлэг"-ийн ерөнхийлөгч проф. Денис Синор, дэд ерөнхийлөгч нь доктор Денис Ж.Бауден, проф. Роберт Виппик болон д-р Ж.Кара, Сисис Дрос (эмэгтэй), д-р Рут И. МесерВэ нарын хүмүүс тэнд ажиллаж байна.

Монголын нийгэмлэгээс монголын судлалын асуудлаар олон төрлийн тогтмол сэтгүүл, ном, толь зэргийг хэвлэн гаргадаг юм. Үүнд: "Монголын нийгэмлэгийн бюллетень"-ийн 1965 оны 6-р сарын 7-ноос гаргах болсон байх бөгөөд 4-12 дугаар гарчээ. "Монголын нийгэмлэгийн сэтгүүл" нь 1974 оноос гарах болсон бөгөөд монгол судлаачдын өгүүлэл, номын шүүмж гэх мэт зүйл ордог байна. 1974-1991 оны хооронд уг сэтгүүлийн 14 боть нь хэвлэгдсэн байна.

"Монголын нийгэмлэгийн мэдээлэл"-ийг 1963 оны 3-р сарын 4-нд гаргажээ. Уг мэдээллийг 1985 оноос шинэ маягаар гаргах болсон бөгөөд түүнд өргөн агуулгатай зүйл ордог байна. Тухайлбал, Монголын амьдрал, ахуйн тухай мэдээлэл гэх мэт. 1985-1992 онд иийтдээ 10 дугаар хэвлэгдэн гарав. Өөр нэг хэвлэл бол "Монголын нийгэмлэгийн тогтмол хэвлэл" бөгөөд гол төлөв монголын судлалын эрдэм шинжилгээний бүтээлийн орчуулга байдаг юм. Тухайлбал, Н.Поппегийн "Халх Монголын баатарлаг туульс"-ийг орос хэлнээс орчуулсан бол, Ж.Крюгер зэрэг хүмүүс Монголын судлалын хэд хэдэн бүтээлийг бусад хэлнээс орчуулан хэвлэсэн бөгөөд уг тэмдэглэлийн 16 дугаар уншигчдийн гарт хүрчээ. "Монголын нийгэмлэгийн тусгай тэмдэглэл" нь Монголын судлалын янз бүрийн эх бичиг, орчин үеийн эх бичгийг монгол хэлээр гаргадаг. Анх 1964 оноос эхэлсэн бөгөөд 1991 он хүртэл 11 дэвтэр гаргасан юм.

АНУ-д монголын судлалын ажлын томоохон хэсгийг монгол хэлний сурах бичиг, хоёр хэлний толь эзэлдэг юм. Фердинанд Д. Лессингийн "Монгол-англи толь", Хангны Гомбожав, Ж.Крюгер нарын "Орчин цагийн монгол-англи толь" (1986 он 25000 үгтэй) гэх мэт толь бичиг, "Монгол хэлний сурах бичиг" (1968 он) бол Монгол улсын хаах аялгуунд үндэслэн зохиогдсон байна. Энэ нь монгол хэл сурах хүмүүст монгол хэлний бүтэц, бичиг зүйтэй танилцах боломж олгосон сурах бичиг болжээ.

Мөн монгол хэл суралцах хүмүүст туслах зорилгоор уг номын эх бичгийг хаах аялгуугаар соронзон бичлэг хийгдсэн байна. 1975 онд монгол хэлний унших бичгийг хэвлүүлсэн зэрэг монгол хэл судлал, англи хэлтэй хүн монгол хэл сурахад зориулсан олон хэрэглэгдэхүүн гаргасан нь АНУ-д монгол хэл сурах, Монголын судлалыг хөгжүүлэхэд голд анхаардагийн илрэл юм. Мөн түүнчлэн монгол дууны пьез, хуурцаг зэргийг нэлээд хэдэн удаа гаргасан байна. Монгол судлалд Америкийн олон эрдэмтэд өөрийн нэрээ оруулсан байна. Жерард Фритерс, Оуэн Латтимор, Жорж Мэфри, Франклин Д.Хольцман, Ж.Гинзбург, Роберт Рупен, Х.Гомбожав, Ж.Крюгер, М.Смит, Д.Синор, Сэцэн Жагчид, М.Сантаро, В.Рихтер зэрэг хүмүүсийг хүндэтгэн нэрлэх ёстой билээ. Нөгөө талаар олон улсын амьдралын тулгамдсан асуудлаар монгол, америкийн хамтран ажиллах талаар чухал алхам хийгдэв. Үүний тодорхой баримт бол Монгол-Америкийн эрдэмтдийн "Ази-Номхон далайн бүс нутаг, одоо, ирээдүй" хэмээх 1,2 бага хурал юм. Тус бага хуралд Роберт А. Скалопино, Сузан Шваб, Харри Хардинг зэрэг Америкийн нэрт эрдэмтэд оролцов.

Ийнхүү монголын судлал нь АНУ-д шинжлэх ухааны бие даасан салбар болж үүсэн тогтож, зохих байр сууриа эзлэн урагшлан хөгжиж байна. Сүүлийн жилүүдэд хоёр орны харилцаа хөгжлийн шинэ шатанд гарсан нь АНУ дахь монгол судлалын батжихад ихээхэн таатай боломж олгож, эрдэмтэд шинжлэх үхзаны олон салбарт хамтран ажиллах болов.

Монгол улсад АНУ судлалын асуудал олон жил хаалттай байлаа. АНУ судлалааар ажиллах судлаачид байхгүй, жижиг улс том гүрнийг судалж болохгүй гэх мэтээр сэтгэн ирэв. Зөвхөн 1991 онд академич Н.Ишжамц, ДДОУСХ-ийн захирал дэд эрдэмтэн Ц.Батбаяр, дэд эрдэмтэн С.Ишдорж, М.Хурметхан зэрэг хэсэг эрдэмтдийн санаачлагаар Монголын АНУ судлалын төв байгуулагдав.

Тус төв байгуулагдахад Монгол оронд АНУ-ын ном зохиол нэвтэрч, америкийн төрийн хүмүүс, эрдэмтэд олноор ирж, монгол хүмүүс америкт очиж тус орны байдалтай танилцах болсон нь чухал үүрэг гүйцэтгэв.

Монголын АНУ судлалын төв бол АНУ-ыг төрөл бүрийн салбарт судлах

эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтан, хамтлаг, ажил төрлийн хувь АНУ-тай холбоо бүхий ажилтан, хувь хүнийг нэгтгэсэн улс төр, үзэл суртла биш, судалгааны сайн дурын олон нийтийн байгууллага мөн билээ. Тус төв

-АНУ-ын түүх, гадаад, дотоод бодлогын зарим асуудал, шинжлэх ухаан, техник, эдийн засаг, боловсрол, соёл, урлаг, үйлчилгээний зэрэг салбар суурь болон хавсарга судалгааг бололцооны хэрээр хийж, хоёр орны хамт ажиллагааг боловсронгуй болгон цаашид хөгжүүлэхэд тус дэм үзүүлэх,

-АНУ-ын эдийн засаг, шинжлэх ухаан, техник, технологи, боловсрол соёл урлаг зэрэг салбар дахь ололтыг судалсны үндсэн дээр тэдгээрээ монгол орны нөхцөлд бүтээлчээр хэрэглэж болох зүйлсийг эрэлхийлэх,

-Үндэсний АНУ судлаачид бэлтгэх, англи хэлний мэдлэг боловсролыг дээшлүүлэх талаар бололцостой бүхнийг хийх,

-Тус орны судалгааны байгууллага, хамтлаг, эрдэмтэд, хүмүүсээс АНУ-ын ижил төрлийн байгууллага, хамтлаг, эрдэмтэд, хувь хүмүүстэй ажил төрлийн хэлхээ холбоо тогтоон, хамтран ажиллахыг хөхүүлэн дэмжих зэрэг зүйлийг өөрийн зорилго болгодог.

Монголын АНУ судлал нь үүсэн бий болж төлөвшин тогтож байгаа бөгөөд монголын америк судлалыг шинжлэх ухааны бие даасан салбар болгон хөгжүүлэхэд санхүүгийн түр зуурын бэрхшээл, мэдлэгийн энэхүү салбар үүсээд асар удаагүй байгаа зэргээс тулгарсаар байгаа бэрхшээлийг даван туулахад манай АНУ судлаачид зориг төгөлдөр байна.